



СЭЛЭНГЭ АЙМАГ  
АЛТАНБУЛАГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 06 сарын 17 өдөр

Дугаар А/193

Алтанбулаг

Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахлаас  
урьдчилан сэргийлэх болон гамшгаас хамгаалах ажлыг  
эрчимжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 7<sup>1</sup> дүгээр зүйлийн 7<sup>1.1</sup>, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1, Эрүүл ахуйн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.2, Сэлэнгэ аймгийн Онцгой комиссын 2021 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн 18 дугаар тогтоол, Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2021 оны 06 дугаар сарын 14-ны өдрийн А/193 дугаар захирамж тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. 2021 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн байдлаар Коронавируст (Ковид-19)-ын халдварын 7 тохиолдол нэмж бүртгэгдсэнтэй холбогдуулан 2021 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн 06:00 цагаас 06 дугаар сарын 21-ний 06:00 цаг хүртэлх хугацаанд сумын орох, гарах тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг түр хязгаарласугай.

2. Коронавируст (Ковид-19)-ын халдварын тохиолдол улсын хэмжээнд эрс нэмэгдэж, хүүхэд халдвар авах, өвчлөх тохиолдол нэмэгдэж байгаа тул хүүхдийг гадаа олон цагаар тоглуулахгүй, олон нийтийн газраар явуулахгүй байхад эцэг эх, асран хамгаалагч нар онцгой анхаарч, иргэн бүр дор бүрнээ хариуцлагатай байж, өөр хот, аймаг руу өөрөө болон гэр бүлийн гишүүн явсан бол буцаж ирснийхээ дараа өөрсдийгөө тусгаарлах зэргээр халдвар хамгааллын дэглэмээ сахин, иргэний үүргээ биелүүлэхийг нийт иргэдэд уриалж ажиллах, ажил зохион байгуулахыг Шуурхай штабын дарга (Ү.Янжиндулам)-д даалгасугай.

3. Хөдөлгөөн хязгаарласан хугацаанд сумын хэмжээнд архи, согтууруулах ундаа худалдан борлуулах, түүгээр үйлчлэхийг хориглож, хяналт тавьж, халдвар хамгааллын дэглэм мөрдүүлэх хууль тогтоомжийн хэрэгжилт хангаагүй аж ахуйн нэгж, байгууллагын мэдээллийг тухай бүр мэдээллэж ажиллахыг Хүнс, жижиг дунд үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн (Б.Одмаа)-д даалгасугай.

4.Замын хөдөлгөөнд оролцож буй тээврийн хэрэгсэл, иргэдийн зорчих хөдөлгөөнд тавих хяналтыг тогтмолжуулах, халдвартай бүс нутгаас ирсэн тусгаарлалтад байгаа болон гарч байгаа иргэдэд хатуу хяналт тавьж ажиллахыг Шуурхай штабын орлогч дарга (Д.Амартүвшин)-д үүрэг болгосугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, хязгаарлалтын үед авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар тухай бүр танилцуулж ажиллахыг Шуурхай штабын дарга (Ү.Янжиндулам)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ОТГОНЦОГТ